




Оясама 140 жилийн ойн баяр



**Оясама 140
жилийн баяр**

**Оясама 140 жилийн ойн баярыг зорин
хамтдаа сүсэг бишрэлийн хөгжилдөө
ахиц дэвшил гаргъя**



1887 оны билгийн тооллын 1-р сарын 26-ны өдөр Оясама дэлхийн хүн төрөлхтнийг аврах гэж яарах эцэг эхийн зүр сэтгэлээс үр хүүхдүүдийгээ сүсэг бишрэлээ улам сайжруулахыг шавдуулах үүднээс махан биеэсээ гарав.

Хэдийгээр одоо бид Оясамагийг харж чадахгүй ч гэсэн Оясама эх үүслийн өргөөнд үүрд саатан дэлхий ертөнц, хүн төрөлхтнийг аврахын тулд одоо ч гэсэн хайр ивээлээ хүртээсээр байгаа билээ.

Тэнрикёо 189 он буюу 2026 оны 1-р сарын 26-ны өдөр Оясама 140 жилийн ойн баярыг тэмдэглэх болно.

Оясама ойн баяр бол арван жилд нэг удаа болдог бүх итгэгчдийн хувьд Оясамагийн хайр энэрэл ачийг нь хариулах чухал үе юм.

Ёобокү бид Оясама ойн баярыг зорин 3 жил мянган өдрийн хугацаанд Үлгэр дуурайлыг мөрдөн, Энх баясгалант амьдралын сургаалыг хэрэгжүүлж, хамтдаа сүсэг бишрэлийн хөгжилдөө ахиц дэвшил гаргъя.

